

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/005/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Дарга, Тэргүүлэх аудитор	Г.Нандинжаргал
	Утас: 70007734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn	
	Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер	
		Х.Түвшинбаяр
	Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn	
	Аудитын менежер:	Я.Алтанцэцэг
Утас: 315093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn		
Ахлах аудитор:	Д.Мөнхдэлгэр	
Утас: 325093 Цахим хаяг: munkhdelgerd@audit.gov.mn		
Аудитор:	Д.Эрдэнэбулган	
Утас: 325093 Цахим хаяг: erdenebulgand@audit.gov.mn		

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДСЭВИЙ АУДИТЫН ГАЗАР
**НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Сойлын төв өргөө Г корпус, 5 давхар,
А.Амарын гудамж, 8 дугаар хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: (976) 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
Цахим шуудан: Ub@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.07.05

№

10/19

талай

-нм №

-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдах байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг харилцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Нийслэлийн Хан-Уул дүүргийн 2025 оны төсвийн орлогын төлөвлөгөөг 578,247.7 сая төгрөг төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 525,468.7 сая төгрөг буюу 52,779.0 сая төгрөгөөр тасарсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзах, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд 601,359.5 сая төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд түүнд нэг удаа тодоргол хийж, 6,934.0 сая төгрөгөөр буюу 1.1 хувиар нэмэгдүүлэн 608,293.5 сая төгрөгөөр баталжээ. Үйл ажиллагаандаа 526,050.6 сая төгрөгийн төсөв зарцуулсан нь өмнөх онтой харьцуулахад 6.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

1426050914

Бусад асуудал

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 бүлэг, 15 зорилго, 90 зорилт, 136 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90.8 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж ажилласан гэж тайлагнасан байна.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралдааны 2024 оны 16 дугаар тогтоолоор тус дүүрэгт 2025 онд хэрэгжих 5 дэд хөтөлбөрийн хүрээнд 22 зорилт, 114 арга хэмжээг төлөвлөн 96.7 хувьтай хэрэгжилттэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	97,077,609.52	117,339,957.09
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	57,672,034.6	61,650,633.13
3	АВЛАГА	852,187.85	535,582.52
4	УРЬДЧИЛГАА	15,498,569.96	18,635,352.16
5	БАРАА МАТЕРИАЛ	2,406,162.5	3,326,518.38
6	НӨӨЦИЙН БАРАА	204,643	0
7	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	20,444,011.62	33,191,870.9
8	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	234,399,062.39	237,814,931.56
9	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	234,399,062.39	237,814,931.56
10	Биет хөрөнгө	231,354,424.27	234,806,674.66
11	Биет бус хөрөнгө	3,044,638.13	3,008,256.9
12	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	331,476,671.92	355,154,888.64
13	НИЙТ ӨР ТӨЛБӨР	9,707,156.43	8,486,687.82
14	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,707,156.43	8,486,687.82
15	Өглөг	3,559,949.62	3,357,719.24
16	Урьдчилж орсон орлого	6,147,206.81	5,128,968.58
17	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	321,769,515.49	346,668,200.82
18	Засгийн газрын хувь оролцоо	321,769,515.49	346,668,200.82
19	Засгийн газрын оруулсан капитал	21,805,055.66	21,805,055.66
20	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	1,056,003	1,056,003
21	Хуримтлагдсан үр дүн	267,971,642.71	292,876,905.57
22	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	30,936,814.12	30,930,236.59
23	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	331,476,671.92	355,154,888.64

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	556,838,083.23	540,180,607.17
2	ТАТВАРЫН ОРЛОГО	444,646,876.64	514,892,493.76
3	Орлогын албан татвар	367,844,561.22	433,084,081.41
4	Хувь хүний орлогын албан татвар	367,844,561.22	433,084,081.41

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

5	Хөрөнгийн албан татвар	26,759,262.58	29,017,118.67
6	Бусад татвар, төлбөр, хураамж	50,043,052.84	52,791,293.68
7	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	91,323,954.12	25,288,113.4
8	Тусламжийн орлого	0.0	1,860,255.72
9	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	20,867,252.47	0.0
10	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	453,441,476.60	511,420,268.46
11	УРСГАЛ ЗАРДАЛ	453,441,476.60	511,420,268.46
12	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	116,469,904.34	134,569,803.27
13	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	18,277,116.39	28,284,745.15
14	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,243,624.36	3,624,822.21
15	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,559,139.27	11,214,933.22
16	Хангамж, бараа материалын зардал	12,087,567.42	4,426,026.91
17	Нормативт зардал	80,335.76	359,309.53
18	Эд хогшил, урсгал засварын зардал	7,670,662.7	5,865,643.12
19	Томилолт, зочны зардал	669,700.46	696,214.49
20	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,926,937.29	51,564,453.24
21	Бараа үйлчилгээний бусад зардал	24,954,820.69	28,533,655.41
22	ТАТААС	292,000	0.0
23	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	336,679,572.30	376,850,465.19
24	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	103,396,606.60	28,760,338.71
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	41,362,860.60	3,867,686.7
26	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-41,362,860.60	-3,867,686.7
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	62,033,745.98	24,892,652

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	480,969,688.6	533,725,393.54
2	ТАТВАРЫН ОРЛОГО	444,646,876.6	514,892,493.76
3	Орлогын албан татвар	367,844,561.2	433,084,081.41
4	Хөрөнгийн албан татвар	26,759,262.6	29,017,118.67
5	Бусад татвар, төлбөр, хураамж	50,043,052.8	52,791,293.68
6	Бусад нийтлэг төлбөр, хураамж	16,523,831.3	17,674,814.26

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

7	Газрын төлбөр	33,459,844.5	35,110,495.05
8	Байгалийн нөөц ашигласны төлбөр	59,377.1	5,984.37
9	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,455,559.5	18,832,899.78
10	Нийтлэг татварын бус орлого	12,354,940.8	14,444,566.1
11	Тусламжийн орлого	0.0	1,860,255.72
12	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	3,100,618.7	2,528,077.96
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	20,867,252.5	0.0
14	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	432,271,552.3	488,659,220.64
15	УРСГАЛ ЗАРДАЛ	432,271,552.3	488,659,220.64
16	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	95,292,727.5	111,840,551.06
17	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	29,135,956.7	40,747,738.49
18	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,625,629.9	5,503,305.01
19	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,320,745.0	12,186,359.73
20	Хангамж, бараа материалын зардал	15,750,986.5	7,416,545.06
21	Нормативт зардал	29,066.3	99,566
22	Эд хогшил, урсгал засварын зардал	7,207,052.2	5,960,900.2
23	Томилолт, зочны зардал	677,263.6	703,037.77
24	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,454,586.9	34,239,365.57
25	Бараа үйлчилгээний бусад зардал	5,091,440.4	4,983,733.22
26	ТАТААС	292,000	0.0
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	336,686,824.8	376,818,669.58
28	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	48,698,136.4	45,066,172.9
29	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	78,251,010.2	41,087,574.37
30	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	78,251,010.2	41,087,574.37
31	Дотоод эх үүсвэрээр	78,251,010.2	41,087,574.37
32	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-78,251,010.2	-41,087,574.37
33	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-29,552,873.8	3,978,598.53
34	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	87,224,908.4	57,672,034.6
35	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	57,672,034.6	61,650,633.13

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	259,958,979.09		259,958,979.09
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-204,175.72		-204,175.72
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	259,754,803.38		259,754,803.38
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-19,033.87		-19,033.87
5	Тайлант үеийн үр дүн	62,033,745.98		62,033,745.98
6	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	321,769,515.49		321,769,515.49
7	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	321,769,515.49		321,769,515.49
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	12,177.52		12,177.52
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	321,781,693.01		321,781,693.01
10	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-6,577.53		-6,577.53
11	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	433.33		433.33
12	Тайлант үеийн үр дүн	24,892,652		24,892,652
13	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	346,668,200.82		346,668,200.82

2.5 Аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	608,293,544.10	526,050,959.12	82,242,584.98	86.5
УРСГАЛ ЗАРДАЛ	608,293,544.10	526,050,959.12	82,242,584.98	86.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	136,564,594.90	111,560,956.71	25,003,638.19	81.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19,433,732.00	15,246,835.19	4,186,896.81	78.5
Үндсэн цалин	6,075,147.90	5,586,063.24	489,084.66	91.9
Нэмэгдэл	3,662,920.00	2,639,140.76	1,023,779.24	72.1
Унаа хоолны хөнгөлөлт	3,158,628.00	2,382,586.25	776,041.75	75.4
Урамшуулал	1,926,588.10	1,564,398.18	362,189.92	81.2
Гэрээт ажлын хөлс	4,610,448.00	3,074,646.77	1,535,801.23	66.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,429,216.40	1,715,976.58	713,239.82	70.6
Тэтгэврийн даатгал	1,651,958.20	1,209,222.32	442,735.88	73.2
Тэтгэмжийн даатгал	194,337.20	133,729.04	60,608.16	68.8
ҮОМШӨ- ний даатгал	100,545.60	50,099.48	50,446.12	49.8
Ажилгүйдлийн даатгал	93,700.60	45,666.80	48,033.80	48.7
Эрүүл мэндийн даатгал	388,674.80	277,258.93	111,415.87	71.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,006,835.80	10,475,898.27	11,530,937.53	47.6
Гэрэл, цахилгаан	8,132,124.90	4,651,379.40	3,480,745.50	57.2
Түлш, халаалт	8,671,981.20	3,277,621.62	5,394,359.58	37.8
Цэвэр, бохир ус	4,298,664.40	1,772,502.18	2,526,162.22	41.2
Байрны түрээс	904,065.30	774,395.06	129,670.24	85.7
Хангамж, бараа материалын зардал	26,345,264.30	24,187,526.05	2,157,738.25	91.8
Бичиг хэрэг	178,914.60	139,697.62	39,216.98	78.1
Тээвэр, шатахуун	152,200.00	67,945.90	84,254.10	44.6
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	329,280.00	228,457.63	100,822.37	69.4
Ном, хэвлэл	82,329.50	39,664.57	42,664.93	48.2
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	25,159,034.90	23,348,869.09	1,810,165.81	92.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	443,505.30	362,891.25	80,614.05	81.8
Нормативт зардал	124,892.00	104,406.20	20,485.80	83.6
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,080.00	899.20	180.80	83.3
Хоол, хүнс	78,000.00	78,000.00	0.00	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	45,812.00	25,507.00	20,305.00	55.7
Эд хогшил, урсгал засварын зардал	4,845,970.00	3,921,567.20	924,402.80	80.9
Багаж, техник, хэрэгсэл	271,927.80	125,018.40	146,909.40	46.0
Тавилга	151,102.80	27,254.62	123,848.18	18.0
Урсгал засвар	4,422,939.40	3,769,294.18	653,645.22	85.2
Томилолт, зочны зардал	903,170.00	698,717.89	204,452.11	77.4
Гадаад албан томилолт	601,990.00	510,265.46	91,724.54	84.8
Дотоод албан томилолт	54,980.00	1,530.00	53,450.00	2.8
Зочин төлөөлөгч хүлээн авах	246,200.00	186,922.43	59,277.57	75.9

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	55,529,863.00	50,921,655.21	4,608,207.79	91.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,093,184.10	50,607,678.51	4,485,505.59	91.9
Даатгалын үйлчилгээ	32,700.00	13,738.53	18,961.47	42.0
Тээврийн хэрэгслийн татвар	30,009.90	4,889.69	25,120.22	16.3
Тээврийн хэрэгслийн оношилгоо	650.00	0.00	650.00	0.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	248,420.00	180,197.64	68,222.36	72.5
Газрын төлбөр	124,299.00	115,150.84	9,148.16	92.6
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	600.00	0.00	600.00	0.0
Бараа үйлчилгээний бусад зардал	4,945,651.40	4,288,374.12	657,277.28	86.7
Бараа үйлчилгээний бусад зардал	4,581,951.40	4,069,422.87	512,528.53	88.8
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	363,700.00	218,951.25	144,748.75	60.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	400,536,957.20	376,693,315.45	23,843,641.75	94.0
Засгийн газрын урсгал шилжүүлэг	398,943,904.20	375,260,911.10	23,682,993.10	94.1
Засгийн газрын дотоод шилжүүлэг	398,943,904.20	375,260,911.10	23,682,993.10	94.1
Бусад урсгал шилжүүлэг	1,593,053.00	1,432,404.35	160,648.65	89.9
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,255.00	15,970.00	5,285.00	75.1
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,505.00	23,842.50	1,662.50	93.5
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,546,293.00	1,392,591.85	153,701.15	90.1
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	71,191,992.00	37,796,686.96	33,395,305.04	53.1
Барилга байгууламж	28,806,410.40	15,831,121.47	12,975,288.93	55.0
Тоног төхөөрөмж	2,097,570.00	1,434,725.35	662,844.65	68.4
Бусад хөрөнгө	40,288,011.60	20,530,840.14	19,757,171.46	51.0
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-27,493,530.20	-1,982,122.61	25,511,407.59	7.2
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-27,493,530.20	-1,982,122.61	25,511,407.59	7.2
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-27,493,530.20	-1,982,122.61	25,511,407.59	7.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		50,134,401.23		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		52,128,318.96		
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,327	1,109	218	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	9	9	0	
Төсвийн байгууллага	9	9	0	
АЖИЛЛАГСДЫН ТОО	659	550	109	
Удирдах ажилтан	47	42	5	
Гүйцэтгэх ажилтан	236	171	65	
Үйлчлэх ажилтан	371	92	279	
Гэрээт ажилтан	5	245	-240	
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	659	550	109	
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	169	114	55	
Төрийн тусгай албан хаагч (ТТ)	7	7	0	
Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	34	26	8	

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	414	126	288	
Гэрээт ажилтан	5	245	-240	
Улс төрийн албан хаагч (УТ)	30	30	0	
Төрийн үйлчилгээний мэргэжлийн (ТҮМ)	0	2	-2	

2.6 Аудит хийсэн нэгдсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

		/мянган төгрөгөөр/
№	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1, 934, 155, 718
2	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1, 934, 155, 718
3	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	1, 934, 155, 718
4	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж / дотоод/	1, 934, 155, 718
5	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	1, 934, 155, 718
6	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1, 934, 155, 718
7	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1, 922,360, 597.01
8	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	1, 922,3860, 597.01
9	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1, 849, 960, 597.01
10	1.1.1.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	33, 980, 000
11	1.1.1.2.1.1.6.1 Багаж, техник, хэрэгсэл	17, 050, 000
12	1.1.1.2.1.1.6.2 Тавилга	16, 930, 000
13	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1, 640, 564, 397.01
14	1.1.1.2.1.1.8.1 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1, 640, 564, 397.01
15	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	176,916, 200
16	1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал	176,916, 200
17	1.1.1.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70, 900, 000
18	1.1.1.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	70, 900, 000
19	1.1.1.2.1.4.2.4 Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	41, 000, 000
20	1.1.1.2.1.4.2.8 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29, 900, 000
21	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	11,795, 120.99
22	1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-11,795, 120.99
23	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-11, 795, 120.99

Гурав. Аудитын илрүүлэлт:

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын эрхлэх хүрээний харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3,970,545.8 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулж, 26,701.6 мянган төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоож, 1,098,245.6 мянган төгрөгийн 10 албан шаардлага хүргүүлж, 545,863.0 мянган төгрөгийн 25 зөвлөмж өгсөн.

Аудитаар нийт 674,308.5 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 1,292.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 557,095.5 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 115,921.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Аудитаар Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын холбогдох заалтыг мөрдөж ажиллах 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

3.1 Албан шаардлага

Хөрөнгө оруулалтын барьцааны өр төлбөрийн 18,057.1 мянган төгрөгийн үлдэгдлийн тооцоог хийж, актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөрийн тооцоог хийж, актаар баталгаажуулаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд

Илрүүлэлт-1: Улсын төсвийн байгууллагуудад 94,263.8 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6-д "тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн төсвийг харьяа төсвийн байгууллагуудын үйл ажиллагаа, дүүргийн иргэдэд шаардлагатай хөрөнгө оруулалтын зардалд зарцуулж байх зөвлөмж өгөв.

Илрүүлэлт-2: Орон нутгийн татварын орлогын гүйцэтгэл 9.2 хувиар (52,893,628.1 мянган төгрөг) тасарч, төлөвлөгөөнөөс дутуу биелсэн байна. Энэ нь Төсвийн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн төсвийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж, төлөвлөгөөний дагуу татварын нэр төрлөөр бүрэн биелүүлэх, хяналт тавьж ажиллах зөвлөмж өгөв.

Илрүүлэлт-3: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд нийт өр төлбөр 14.4 хувиар буурсан боловч харьяа байгууллагуудын тайлант оны татварын өглөг, дансны өглөг нийт 85.7 хувиар (662,907.9 мянган төгрөг) өсөж, өглөг үүсгэн ажилласан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 15 дугаар зүйлийн 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх" заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг зохистой удирдаж өр төлбөр үүсгэсэн эсэхэд анхаарах, барагдуулах арга хэмжээнд хяналт тавих зөвлөмж өгөв.

Илрүүлэлт-4: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагад санхүүгийн тайлангийн аудитаар залруулсан 3,970,545.8 мянган төгрөг, залруулагдаагүй 9,810,738.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37-д "төсвийн төвлөрүүлэн захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг" заасантай нийцэхгүй байна. заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлж, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулан, үр дүнг тайлагнах зөвлөмж өгөв.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дөрөв. Аудитаар
илэрхийллийн нэгтгэл:

илэрсэн буруу

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
	Хан-Уул дүүргийн ТТЗ												
1	Хан-Уул дүүргийн ЗДТГ	5	116,656.9			5	116,656.9	5	116,656.9				
2	Хан-Уул дүүргийн ИТХ	3	147,315.0	1	135,900.0	2	11,415.0	3	147,315.0				
3	Хан-Уул дүүргийн Хөрөнгө оруулалт												
4	Хан-Уул дүүргийн ОНХС												
5	Хан-Уул дүүргийн Барьцаа хөрөнгө												
6	Хан-Уул дүүргийн Байгаль хамгаалах сан												
7	Хан-Уул дүүргийн Дотоод аудитын алба												
8	Хан-Уул дүүргийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв	1	7,000.0	1	7,000.0			1	7,000.0				
9	Хан-Уул дүүргийн Худалдан авах ажиллагааны алба												
10	Хан-Уул дүүргийн Соёлын ордон	1	38,961.5	1	38,961.5			1	38,961.5				
11	Хан-Уул дүүргийн Усан спорт сургалтын төв	1	2,305.7	1	2,305.7			1	2,305.7				
12	Хан-Уул дүүргийн Туул тосгоны ажлын алба												
	Орон нутгийн төсвийн байгууллагуудын дүн	11	312,239.1	4	184,167.2	7	128,071.9	11	312,239.1				
13	Хан-Уул Яармаг худалдааны төв ОНӨААТҮГ												
14	Хан-Уул дүүргийн Эко ахмадын сувилал ОНӨААТҮГ												
15	Хан-Уул дүүргийн Зам засвар, арчлалт ОНӨААТҮГ	1	105,996.1			1	105,996.1	1	105,996.1				
16	Хан-Уул дүүргийн Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ												
17	Хан-Уул дүүргийн Хан эко тээвэр ОНӨААТҮГ												
18	Хан-Уул дүүргийн Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ	1	3,490,757.4			1	3,490,757.4	1	3,490,757.4				
19	Хан-Уул агро ОНӨААТҮГ												
20	Хан-Уул дүүргийн Эко хотын тээвэр ОНӨААТҮГ	2	61,553.2			2	61,553.2	2	61,553.2				

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

21	Хан-Уул дүүргийн теле камерын дэд төв ОНӨААТҮГ												
	ОНӨААТҮГ-ын дүн	4	3,658,306.7			4	3,658,306.7	4	3,658,306.7				
	НИЙТ ДҮН	15	3,970,545.8	4	184,167.2	11	3,786,378.6	15	3,970,545.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Хан-Уул дүүргийн ТТЗ	5	112,320.9			1	18,057.1	4	94,263.8				
1	Хан-Уул дүүргийн ЗДТГ	3	384,891.3			1	154,000.0	2	230,891.3				
2	Хан-Уул дүүргийн ИТХ	4	674,308.5	1	1,292.0	2	557,095.5	1	115,921.0				
3	Хан-Уул дүүргийн Хөрөнгө оруулалт												
4	Хан-Уул дүүргийн ОНХС												
5	Хан-Уул дүүргийн Барьцаа хөрөнгө												
6	Хан-Уул дүүргийн Байгаль хамгаалах сан												
7	Хан-Уул дүүргийн Дотоод аудитын алба	1	5,822.4					1	5,822.4				
8	Хан-Уул дүүргийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв	1	9,944.6					1	9,944.6				
9	Хан-Уул дүүргийн Худалдан авах ажиллагааны алба	2	21,260.0					2	21,260.0				
10	Хан-Уул дүүргийн Соёлын ордон	1	2,081.4					1	2,081.4				
11	Хан-Уул дүүргийн Усан спорт сургалтын төв												
12	Хан-Уул дүүргийн Туул тосгоны ажлын алба	1	11,757.7					1	11,757.7				
	Орон нутгийн төсвийн байгууллагуудын дүн	13	1,110,065.9	1	1,292.0	3	711,095.5	9	397,678.4				
13	Хан-Уул Яармаг худалдааны төв ОНӨААТҮГ												
14	Хан-Уул дүүргийн Эко ахмадын сувилал ОНӨААТҮГ	3	18,508.0			1	7,588.0	2	10,920.0				
15	Хан-Уул дүүргийн Зам засвар, арчлалт ОНӨААТҮГ	3	22,670.7			1	19,570.7	2	3,100.0				
16	Хан-Уул дүүргийн Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ	3	25,362.8			1	288.0	2	25,074.8				

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

17	Хан-Уул дүүргийн Хан эко тээвэр ОНӨААТҮГ	3	22,461.5					3	22,461.5			
18	Хан-Уул дүүргийн Тохжилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ	5	43,490.7	1	12,150.0	1	-	3	31,340.7			
19	Хан-Уул агро ОНӨААТҮГ	6	85,284.1	2	11,675.6	1	18,320.9	3	55,287.6			
20	Хан-Уул дүүргийн Эко хотын тээвэр ОНӨААТҮГ	4	342,966.5	1	1,584.0	2	341,382.5	1	-			
21	Хан-Уул дүүргийн теле камерын дэд төв ОНӨААТҮГ											
	ОНӨААТҮГ-ын дүн	27	560,744.3	4	25,409.6	7	387,150.1	16	148,184.6			
	НИЙТ ДҮН	45	1,783,131.1	5	26,701.6	11	1,116,302.7	29	640,126.8			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Хан-Уул дүүргийн ТТЗ	1	468,487.7					1	468,487.7		
1	Хан-Уул дүүргийн ЗДТГ	5	2,118,130.3	1	2,500.0	4	2,115,630.3				
2	Хан-Уул дүүргийн ИТХ	6	4,358,343.0			6	4,358,343.0				
3	Хан-Уул дүүргийн Хөрөнгө оруулалт										
4	Хан-Уул дүүргийн ОНХС										
5	Хан-Уул дүүргийн Барьцаа хөрөнгө										
6	Хан-Уул дүүргийн Байгаль хамгаалах сан										
7	Хан-Уул дүүргийн Дотоод аудитын алба	1	9,379.5			1	9,379.5				
8	Хан-Уул дүүргийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв	1	46,918.7					1	46,918.7		
9	Хан-Уул дүүргийн Худалдан авах ажиллагааны алба	2	10,277.2			1	10,277.2	1	-		
10	Хан-Уул дүүргийн Соёлын ордон	1	48,288.8					1	48,288.8		
11	Хан-Уул дүүргийн Усан спорт сургалтын төв	1	11,091.0					1	11,091.0		
12	Хан-Уул дүүргийн Туул тосгоны ажлын алба	1	-					1	-		
	Орон нутгийн төсвийн байгууллагуудын дүн	18	6,602,428.6	1	2,500.0	12	6,493,630.1	5	106,298.5		
13	Хан-Уул Яармаг худалдааны төв ОНӨААТҮГ										

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

14	Хан-Уул дүүргийн Эко ахмадын сувилал ОНӨААТҮГ	2	266,800.0			1	266,800.0	1	-		
15	Хан-Уул дүүргийн Зам засвар, арчлалт ОНӨААТҮГ										
16	Хан-Уул дүүргийн Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ										
17	Хан-Уул дүүргийн Хан эко тээвэр ОНӨААТҮГ	1	-					1	-		
18	Хан-Уул дүүргийн Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ										
19	Хан-Уул агро ОНӨААТҮГ	3	167,232.7	1	4,469.0	2	162,763.7				
20	Хан-Уул дүүргийн Эко хотын тээвэр ОНӨААТҮГ	1	522,657.9			1	522,657.9				
21	Хан-Уул дүүргийн теле камерын дэд төв ОНӨААТҮГ										
	ОНӨААТҮГ-ын дүн	7	956,690.6	1	4,469.0	4	952,221.6	2	-		
	НИЙТ ДҮН	26	8,027,606.9	2	6,969.0	16	7,445,851.7	8	574,786.2		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТТЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			